

## ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Дугаар № 134 / 2022

2022 оны 12 р сарын 20

Улаанбаатар хот

Энэхүү түрээсийн гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө /цаашид түрээслэгч гэх/, нөгөө талаас түрээслүүлэгч иргэн А.Батболд рд-78022571 /цаашид түрээслүүлэгч гэх /хамтад нь/ цаашид талууд гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 318-326 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний зорилго

- 1.1. Гэрээний зорилго нь “Зуухны нарийн үнсийг зориулалтын автомашинаар тээвэрлэх” ажлыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэх, Түрээслэгч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Гэрээний нөхцөл, ерөнхий зүйл, хугацаа

- 2.1. Түрээслүүлэгч нь “Зуухны нарийн үнс зориулалтын автомашинаар тээвэрлэх” (цаашид “ажил” гэх) -ыг 29-08 УНХ улсын дугаартай Dong Fong DFL 1250 маркийн өөрийн эзэмшлийн автомашинаар эзэмшигч А.Батболд нь 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр багтаан гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно.

### Гурав. Түрээсийн төлбөр


- 3.1. Зуухны нарийн үнсийг зориулалтын автомашинаар тээвэрлэх ажлын үнэ нь нэг тонн үнсийг 20,000 /хорин мянга /-н төгрөгөөр тээвэрлэнэ. Шатахууны үнэ ороогүй дүн болно. Энэ нь НӨАТ, даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.
- 3.2. Гэрээт ажлын төлбөрийг пүүний бичиг, жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн гүйцэтгэлээр нь сар бүрийн эхний 10 /арав/ хоногт багтаан нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Хаан банкны 5075406032 тоот дансанд шилжүүлнэ.

### Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах


- 8.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2. Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил гүйцэтгээгүй хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд түрээслэгчийн санаачилгаар гэрээг цуцална.

### Ес. Бусад зүйл


- 9.1. Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж гэрээг дүгнэснээр дуусгавар болно.
- 9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Түрээслэгч 3 хувийг Түрээслүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.
- 9.6. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

БАТЛАВ  
УЛААНБААТАР ХОТ  
ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТЭХ ЗАХИРАЛ  
  
М.МӨНХӨӨ

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

  
Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

БАТЛАВ  
ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ИРГЭН  
  
А.БАТБОЛД

 Ө.УДВАЛ

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТТУЛГА

АХММХМ ИНЖЕНЕР



Н.САЙНБИЛЭГ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ



ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ш.ГАНТУЛГА

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646*

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг 19-р хороо цайзын  
17-195 тоот  
Утас: 89740110  
РД: рэ-78022571.*